



ДОРНОГОВЬ АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ,
ЭДИЙН ЗАСГИЙН ТАНИЛЦУУЛГА

2021/07

САЙНШАНД ХОТ

ГАРЧИГ

Товч танилцуулга.....	1-15
Нийгэм, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд.....	16
Нэг. Эрүүл мэнд.....	17-18
Хоёр. Хөдөлмөр эрхлэлт	19-21
Гурав. Нийгмийн даатгал, халамж.....	22-25
Дөрөв. Гэмт хэрэг.....	26-27
Тав. Мөнгө,зээл	28
Зургаа. Төсөв, санхүү	29-30
Долоо. Үнэ.....	31-34
Найм. Хөдөө аж ахуй	35-37
Ес. Аж үйлдвэр.....	38-42
Арав. Байгаль орчин	43



ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

(2021 оны 07 дугаар сарын байдлаар)

Нэг. Нийгмийн үзүүлэлт




1.1 Хүн ам

Дорноговь аймгийн хэмжээнд 2021 оны 07 сард 865 эх амаржиж, 874 хүүхэд шинээр мэндэлж, 197 хүн нас барсан байна. Амаржсан эхийн тоо өмнөх оны мөн үеэс 42(5.1%)-оор, төрсөн хүүхдийн тоо өмнөх оны мөн үеэс 43(5.2%)-аар, нас барсан хүний тоо өмнөх оны мөн үеэс 3(1.5%)-аар тус тус өссөн байна.

Хүн амын цэвэр өсөлт 677 болж 2020 оны мөн үеийнхээс 40(6.3%)-өөр өссөн байна. 1000 хүнд ногдох төрөлт 12.2, нас баралт 2.8 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад төрөлт 0.4 пунктээр өсч, нас баралт өмнөх оны мөн үетэй адил хэмжээнд байна.

Зураг. Төрсөн хүүхэд, нас барсан хүний тоо. 2018-2021 оны 07 сард



Он гарсаар нялхсын эндэгдэл 10 байгаа нь өмнөх оны мөн үетэй адил хэмжээнд байна.



1.2 Эрүүл мэнд

2021 оны эхний 07 сарын байдлаар 265.0 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 16.4 хувиар, 6.9 мянган хүн урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 3.0 хувиар тус тус өсч, 9.7 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 6.7 хувиар буурчээ.




2021 оны эхний 07 сард 970 эх жирэмсний хяналтанд орсны 93.1 хувь буюу 903 эх жирэмсний эхний 3-н сард хяналтанд хамрагджээ. Жирэмсний хяналтанд хугацаандаа орсон эхийн эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 2.5 пунктээр өссөн байна.

Түргэн тусламжийн дуудлага 10.7 мянган удаа гарсны 1.8 мянга буюу 16.8 хувь нь алсын дуудлага байв. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт түргэн тусламжийн дуудлага өмнөх оны мөн үеэс 7.8 хувиар, алсын дуудлага 14.3 хувиар тус тус буурсан байна.

Он гарсаар ослын улмаас 1435 хүн бэртэж, 33 иргэний амь нас энджээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал бэртэж гэмтсэн хүний тоо 284(16.5%)-өөр буурч, нас барсан хүний тоо өмнөх оны мөн үетэй адил хэмжээнд байна.

Зураг. Нас баралт, өвчний шалтгаанаар, хувь. 2021 оны 07 сард



Нас баралтыг өвчний шалтгаанаар авч үзэхэд хавдар 29.9 хувь, цусны эргэлтийн тогтолцооны өвчин 22.8 хувь, осол, гэмтэл хордлого гадны шалтгаант үхэл өвчин 16.8 хувь, бусад төрлийн өвчин 16.2 хувь, амьсгалын тогтолцооны өвчин 7.1 хувь, хоол шингээх эрхтний өвчин 7.1 хувийг тус тус эзэлж байна.

Халдварт өвчний 571 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 154-өөр буюу 36.9 хувиар өсчээ. Нийт бүртгэгдсэн халдварт өвчний 58.1 хувь буюу 332 нь шинэ төрлийн коронавируст халдварын тохиолдол юм. 2021 оны 07 сарын байдлаар Айраг суманд 12, Даланжаргалан суманд 11, Иххэт суманд 7, Өргөн суманд 1, Эрдэнэ суманд 7, Сайншанд суманд 117, Замын-Үүд суманд 125, Сайхандулаан-суманд 37, Хатанбулаг суманд 3, Зүүнбаян багт 7, Сулинхээр ЦА-д 5 тохиолдол тус тус бүртгэгдээд байна.




1.3 Хөдөлмөр эрхлэлт

Хөдөлмөрийн хэлтэст ажил хайж бүртгүүлсэн иргэд 2021 оны 07 сарын эцэст 577 болсны 562 (97.4%) нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 15 (2.6%) нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна.

Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд нь өмнөх оны мөн үеийнхээс 166(40.4%) хүнээр, өмнөх сараас 10 (1.8%) хүнээр илүү байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн боловсролын түвшинг харахад 323(56.0%) нь бүрэн дунд, 120(20.7%) нь дээд, 63(10.9%) нь тусгай дунд, 23(4.0%) нь техник мэргэжлийн, 30(5.2%) нь бүрэн бус дунд, 9(1.6%) нь боловсролгүй, 5(0.9%) нь бага, 4(0.7%) магистр, докторын боловсролтой иргэд эзэлж байна.

Зураг. Ажилгүй иргэдийн тоо, боловсролоор, хувиар, 2021 оны 07 сарын эцэст




Хөдөлмөрийн хэлтэст 2021 оны 07 сард шинэ ажлын байранд 224 иргэн орсны 75 нь байнгын ажлын байр, 5 нь улирлын чанартай, 144 нь түр ажлын байранд орсон байна.

Хөдөлмөрийн хэлтсээр дамжуулан ажилд зуучлагдан орсон иргэд 2021 оны 07 сарын эцэст 368 иргэн болсны 189 нь эмэгтэй байна. Тухайн сард бүртгэлтэй байсан 10 иргэн ажилд зуучлагдан орж, өмнөх сарын бүртгэлээс 52 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар хасагдсан байна.




Зураг. Ажилд зуучлагдан орсон иргэдийн тоо, ажил мэргэжлийн ангилалаар 2021 оны 07 сарын эцэст



1.4 Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгалын хэлтсийн мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 2021 оны 07 сарын байдлаар 30533.9 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 6492.3 (27.0%) сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Нийгмийн даатгалын сангийн орлого 2021 оны 07 сард өмнөх оны мөн үеэс 6492.3 сая төгрөгөөр нэмэгдэхэд тэтгэврийн даатгал 6486.5 (43.0%) сая төгрөг, тэтгэмжийн даатгал 87.5 (5.1%) сая төгрөг, эрүүл мэндийн даатгал 991.3 (24.7%) сая төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Зураг. Нийгмийн даатгалын сангийн орлого сангийн төрлөөр /сая.төг/ 2021 оны 07 сард





Нийгмийн даатгалын сангийн зарлага 36729.3 сая.төг болж өмнөх оны мөн үеэс 2175.3 (6.3%) сая.төгрөгөөр өссөн байна. Зарлагыг бүтцээр нь авч үзвэл тэтгэврийн даатгалын сангаас 27267.5 (74.2%) сая.төг, эрүүл мэндийн даатгалын сангаас 5010.1 (13.6%) сая.төг, тэтгэмжийн даатгалын сангаас 2069.9 (5.6%) сая.төг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 1596.3 (4.3%) сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 785.5 (2.1%) сая төгрөгийг зарцуулжээ.

Зураг. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, сая төг



Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээллээр нийгмийн халамжийн сангаас 2021 оны эхний 07 сард нийгмийн халамжийн сангаас 10597 иргэнд 2630.4 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгожээ. Өмнөх онтой харьцуулахад хамрагдсан иргэд 11736 (52.6%)-оор, олгосон тэтгэвэр тэтгэмж 2522.9 (49.0%) сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Нийгмийн халамжийн сангийн зарцуулалт буурсан нь 2020 оны 09-р сараас эхлэн цалинтай ээж хөтөлбөр, жирэмсэн эхийн тэтгэмж, алдарт эхийн одонгийн тусламж, насны хишиг, ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх, иргэнд олгох тэтгэмж, өрх толгойлсон эцэг, эхийн тэтгэмжүүд и-халамж цахим системд шилжиж ХХҮЕГ-аас шууд арилжааны банкууд шилжүүлэг хийгддэг болсонтой холбоотой юм.

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2021 оны 07 сард 1304 хүн хамрагдсан нь өмнөх оноос 34(2.5%)-өөр, олгосон тэтгэвэрийн хэмжээ 971.9 сая төгрөг болж 1045.0 (51.8%) сая төгрөгөөр тус тус буурчээ.

Нийгмийн халамжийн тэтгэмж 1154 иргэнд 690.0 сая төгрөг, амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж 1045 иргэнд 584.4 сая төгрөг болон нийгмийн халамжийн сангаас 29 иргэнд 34.8 сая төгрөгийг зарцуулсан байна.


Бусад төрлийн халамжийн үйлчилгээнд 7065 иргэн хамрагдаж, 348.3 сая төгрөгийг олгожээ.



Зураг. Хүний тоо



Зураг. Олгосон тэтгэвэр, тэтгэмж /сая. төг/




1.5 Гэмт хэрэг

Аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн мэдээгээр 2021 оны 07 дугаар сарын байдлаар 246 хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 97 хүн гэмтэж, 10 хүн нас барсан байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 3(1.2%)-аар буурч, гэмтсэн хүний тоо 35(56.5%)–аар өссөн байна. Гэмт хэргийн улмаас нас барсан хүний тоо өмнөх оны мөн үетэй адил хэмжээнд байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг 44(2.0 дахин)-өөр, хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 4(50%)-өөр тус тус өсч, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 5(38.5%)-аар, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 8(61.5%)-аар, хүн амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 1(11.1%)-ээр, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 28(20.6%)-аар, тус тус буурч, нийтийн ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг өмнөх оны мөн үетэй адил хэмжээнд, улсын хилээр хууль бусаар эд зүйлс нэвтрүүлсэн гэмт хэрэг, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг бүртгэгдээгүй байна.




Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сараар



Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 43.9 хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 35.8 хувийг хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг, 4.9 хувийг хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 2.4 хувийг олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг, 2.4 хувийг нийтийн шиг сонирхлын эсрэг гэмт хэрэг, 2.0 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, 0.4 хувийг бусад төрлийн гэмт хэргүүд эзэлж байна. Согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 58 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16(38.1%)-аар нэмэгдсэн байна.

Гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс Мандах, Хатанбулаг, Хөвсгөл, Сайншанд, Замын-Үүд сумдад нэмэгдэж, Иххэт суманд өмнө оны мөн үеийнхтэй адил, бусад сумдад гэмт хэргийн тоо буурсан байна.

Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сумаар






Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 463.6 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1350.6 (74.4%) сая төгрөгөөр буурсан байна. Учирсан хохирлын 232.6 (57.5%) сая төгрөг эргэн төлөгдсөн байна.

Нийт гэмт хэргийн 104(42.3%) нь гэр орон сууцандаа, 58(23.6%) нь согтуугаар, 33(13.4%) нь гудамж олон нийтийн газарт, 12(4.9%) бүлэглэн, 24(9.8%) хувийг эмэгтэй хүн оролцон, 69(28.0%) нь өдрийн цагаар /14-19 цагт/ үйлдсэн байна. Тайлант хугацаанд нийт 660 хүн саатуулагдаж, 125 хүн баривчлагджээ.

Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн бүтэц, хэрэг үйлдэгдсэн цагаар 2021 оны 07 сард




Хоёр. Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт



2.1 Мөнгө, банк


Монгол банкны 7-р сарын мэдээгээр арилжааны банкуудын зээлдэгчийн тоо 33.8 мянга болж өмнөх оноос 2.3(6.4%) мянган хүнээр буурч, нийт хадгаламжийн данс эзэмшигчийн тоо 79.2 мянга болж өмнөх оны мөн үеэс 10.6 хувиар өссөн байна.

Зураг. Хадгаламжийн үлдэгдэл, зээлийн өрийн үлдэгдэл, 2020-2021 он, сая.төг





Зураг. Хадгаламж эзэмшигч, зээлдэгчийн тоо, 2020- 2021 он, мян.хүн



Нийт хадгаламжийн үлдэгдэл 200.9 тэрбум төгрөг болж үүнээс иргэдийн хадгаламж 187.5 тэрбум төгрөг байна. Нэг хадгаламж эзэмшигчид дунджаар 2535.5 мянган төгрөг, аймгийн нэг хүнд дундажаар 2634.0 мянган төгрөгийн хадгаламж ногдож байна. Хадгаламжийн үлдэгдлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 63.1(45.8%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл сарын эцэст 6.9 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 6.6(0.1%) сая төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 371.2(5.7 %) сая төгрөгөөр өсчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 2.4 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 0.1 пунктээр буурчээ.


Чанаргүй зээл сарын эцэст 13.4 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 700.0(1.1%)сая төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 1686.2(14.4%) сая төгрөгөөр өссөн байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 4.6 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 0.1 пунктээр өссөн байна.

Зураг. Зээл, төрлөөр, тэрбум төгрөг, 2021.07 сард






Зураг. Зээлдэгчийн тоо, зээлийн төрлөөр, 2021.07 сард



2.2 Төсөв, санхүү

2021 оны 07 дугаар сарын байдлаар орон нутгийн төсөвт 18493.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлжээ. Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 84.8 хувь байна. Өмнөх оны мөн үетэй төсвийн орлогын дүнг харьцуулахад 15.6 хувиар буурсан байна. Аймгийн орон нутгийн төсвийн орлогын 83.9 хувийг татварын, 5.6 хувийг татварын бус орлого, 10.5 хувийг хөрөнгийн орлого бүрдүүлсэн байна.

Зураг. Орон нутгийн төсвийн орлого, зарлагын бүтэц, хувиар, 2021 оны 07 сард





Улсын нэгдсэн төсөвт ААНБ-ын орлогын албан татвар, дотоодын бараа, үйлчилгээний татвар, ашигт малтмал нөөц ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөр, өсөн нэмэгдэх нөөц ашигласны төлбөр, ус бохирдуулсны төлбөр нийт 5138.3 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын дүнг өмнөх оны мөн үеэс 7.9 хувь буюу 439.3 сая.төг-өөр дутуу, төлөвлөгөөнөөс 8.9 хувь буюу 420.1 сая.төг-өөр давуулан биелүүлсэн байна.



2.3 Үнэ


Хэрэглээний үнийн индекс (ХҮИ) гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт ерхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

Хэрэглээний үнийн индекс 2021 оны 07 дугаар сарыг өмнөх сартай харьцуулахад 1.2 хувиар, өмнөх оны мөн үеэс 7.9 хувиар тус тус өсчээ.

Ерөнхий индекс өмнөх сартай харьцуулахад 1.2 хувиар өсөхөд: согтууруулах бус ундааны бүлэг 0.3 хувь, хувцас бөс бараа, гутлын бүлэг 3.4 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлэг 0.9 хувь, гэр ахуйн тавилгын бүлэг 3.4 хувь, эм тариа эмнэлэгийн үйлчилгээний бүлэг 1.4 хувь, тээврийн бүлэг 4.2 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлэг 0.1 хувиар тус тус өссөн нь нөлөөлсөн байна.


Ерөнхий индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.9 хувиар өсөхөд: хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 12.9 хувь, согтууруулах бус ундааны бүлэг 2.0 хувь, хувцас бөс бараа, гутлын бүлэг 8.2 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлэг 2.3 хувь, гэр ахуйн тавилгын бүлэг 9.5 хувь, эм тариа эмнэлэгийн үйлчилгээний бүлэг 11.5 хувь, тээврийн бүлэг 6.7 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлэг 2.1 хувь, зочид буудал, зоогийн газар, дотуур байрны үйлчилгээний бүлэг 10.9 хувь, бусад бараа үйлчилгээний бүлэг 3.2 хувь тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2021 оны 07 дугаар сарын өөрчлөлт, бүлгээр, хувиар (өмнөх сар=100)






Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2020-2021 оны үнийн өөрчлөлт, сар бүрээр (өмнөх сар=100)



Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2018 -2021 оны 07 дугаар сар (өмнөх оны 7-р сар=100)



Гурав. Эдийн засгийн статистикийн үзүүлэлт



3.1 Хөдөө аж ахуй


Аймгийн хэмжээнд 2021 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 1083.4 мянган хээлтэгч малын 712.1 мянга (65.7%) нь 2021 оны эхний 07 сард төллөсөн байна. Эм хонины 73.7 хувь, эм ямааны 62.4 хувь, үнээний 50.1 хувь, гүүний 44.6 хувь, ингэний 42.4 хувь нь төллөжээ.



Гарсан төлийн 97.4 хувь буюу 694.9 мянган төл бойжиж байна. Бойжуулсан төл өмнөх оны мөн үеэс 37.9 (5.2%) мянгаар бага байна. Дэлгэрэх суманд 77.9 мянга, Хатанбулаг 74.7, Иххэт суманд 67.1 мянга, мянга, Алтанширээ суманд 62.1 мянга, Даланжаргалан суманд 59.3, Айраг суманд 50.0 мянган төл тус тус бойжсон нь нийт бойжсон төлийн 56.3 хувийг эзэлж байна.

Том малын зүй бус хорогдол 2021 оны эхний 07 сард аймгийн хэмжээнд 28368 болж, өмнөх оны мөн үеэс 27474 (31 дахин) толгойгоор илүү байна. Нийт хорогдсон малын 53.9 хувийг ямаа, 37.1 хувийг хонь эзэлж байна.

Зураг. Том малын зүй бусын хорогдол, жил бүрийн 07 сард



Малын зах зээлийн дундаж үнийн мэдээгээр нас гүйцсэн ат Хөвсгөл суманд хамгийн их буюу 1550.0 мянган төгрөг, Эрдэнэ, Замын-Үүд сумдад хамгийн бага буюу 1000.0 мянган төгрөг, соёолон үрээ Сайншанд суманд их буюу 1300.0 мянган төгрөг, Эрдэнэ, Замын-үүд сумдад хамгийн бага буюу 800.0 мянган төгрөг, хязаалан гуна Алтанширээ суманд хамгийн их буюу 1500.0 мянган төгрөг, Замын-үүд суманд хамгийн бага буюу 1000.0 мянган төгрөг байна. Нас гүйцсэн эр хонины дундаж үнэ Дэлгэрэх суманд хамгийн их буюу 290.0 мянган төгрөг, Улаанбадрах суманд хамгийн бага буюу 180.0 мянган төгрөг, нас гүйцсэн эр ямааны дундаж үнэ Хөвсгөл суманд хамгийн их буюу 200.0 мянган төгрөг, Мандах суманд хамгийн бага буюу 85.0 мянган төгрөг байна.

Зураг. Нас гүйцсэн эр хонины дундаж үнэ, 2021 оны 07 сард, мянган төгрөгөөр





3.2 Аж үйлдвэр

Оны эхний 07 сарын байдлаар аж үйлдвэрийн салбарт 149143.0 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 335107.7 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг зах зээлд борлууллаа. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 58836.2 сая төгрөгөөр буюу 65.2 хувиар, нийт борлуулалт 189295.1 сая төгрөгөөр буюу 2.3 дахин өссөн байна.

2021 оны 07 сарын байдлаар аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 65.2 хувиар өсөхөд уул, уурхай олборлох салбарын үйлдвэрлэлт өмнөх оноос 50357.9 сая төгрөгөөр, боловсруулах салбарын үйлдвэрлэлт 7997.7 сая төгрөгөөр, усан хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагааны салбар 469.8 сая төгрөгөөр, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлийн салбар 10.8 сая төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 4.3 хувийг төрийн, 95.7 хувийг хувийн өмчийн аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэжээ.

Аж ахуйн нэгжийн хариуцлагын хэлбэрээр авч үзвэл улсын үйлдвэрийн газар 4.3 хувь, компани 95.2 хувь, өрхийн аж ахуй 0.5 хувийг тус тус эзэлж байна.

Статистикийн мэдээлэлд хамрагдсан гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дулаан 17.1 мян.ккал-аар, ус түгээлт 63.1 мян.м³-аар, сувагжуулалт 81.3 мян.м³-аар, савласан цэвэр ус 922.3 мян.литрээр, бялуу 1.4 тонноор, хиам 13.8 тонноор, сүүн бүтээгдэхүүн 5.0 мян.литрээр, банш, бууз 3.8 тонноор, гутал 55 ширхгээр, нүүрс 861.5 мян.тонноор, шохой 7450.0 тонноор, цемент 115.9 мян.тонноор тус тус илүү үйлдвэрлэгджээ.

Дөрөв. Байгаль орчны статистикийн үзүүлэлт



4.1 Байгаль орчин

Цаг уур

Температур: 7-р сарын дундаж агаарын температур нийт нутгаар 22.9 – 26.1 градус дулаан, агаарын хамгийн их температур өдөртөө нийт нутгаар 35 - 38 градус дулаан байлаа. Агаарын дундаж температурыг олон жилийн дундаж /ОЖД/-тай харьцуулахад: Сайншанд, Мандах, Хөвсгөл, Эрдэнэ, Алтанширээ сумдын нутгаар ОЖДундаж орчим байлаа. Бусад сумдын нутгаар ОЖД-аас дулаан. Хөрсний гадарга дээр нийт нутгаар шөнөдөө 9.0 - 12.0 градус дулаан, өдөртөө 58 - 65 градус дулаан байв.

Хур тунадас: Энэ сард нийт нутгаар бороо 4 - 11 өдөр бороотой байлаа. Сайншанд суманд 60.7 мм, Замын-Үүд суманд 90.7 мм, Мандах суманд 80.7 мм, Хөвсгөл суманд 82.7 мм, Дэлгэрэх суманд 20.1 мм, Эрдэнэ суманд 73.3 мм, Айраг суманд 35.7 мм, Алтанширээ суманд 4.6 мм, Өргөн суманд 31.0 мм, Сайхандулаан суманд 57.9 мм, Улаанбадрах суманд 80.1 мм, Хатанбулаг суманд 136.1 мм бороо орлоо. Орсон хур тунадасны нийлбэрийг олон жилийн дундаж /ОЖД/-тай



харьцуулахад: Өргөн, Дэлгэрэх, Алтанширээ сумдад ОЖД-аас бага, Айраг суманд ОЖДундаж орчим. Бусад сумлын нутгаар ОЖД-аас ахиу бороо орсон байна.

Салхи: Энэ сард салхины хамгийн их хурд Айраг, Алтанширээ суманд 9 - 12 м/с, бусад сумдын нутгаар 14 - 23 м/с хүрсэн. 10 м/с-ээс дээш салхитай хоногийн тоо Хатанбулаг, Сайхандулаан сумдад 1 өдөр, бусад сумдад 4 - 17 өдөр салхи ихтэй, зарим үед цаг агаар тогтворгүй байлаа.

Бэлчээрийн ургамал: Бэлчээрийн ургамлын дундаж өндөр 6- 18 см, бэлчээрийн ургамлын ургалтын байдал сумын нутгийн 4 зүгийн үнэлгээгээр Эрдэнэ, Сайншанддын зүүн, Айрагын баруун, зүүн, өмнө, Иххэтийн өмнө хэсгээр дунд зэрэг, бусад нутгаар сайн байна. Өргөн, Сайхандулаан, Замын-Үүд ихэнх хэсгээр дунд ургамал шарлаж хатаж байна.

МАА-н үйлдвэрлэлд: Цаг агаарын нөхцлөөс болж малын бэлчээрлэлт саатсан тохиолдол гараагүй. Нийт нутгаар отор нүүдэл хийж мал ногоолуулах ажил явагдлаа. Малын усан хангамж ихэнх нутгаар дунд зэрэг байлаа.



ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ
(2021 ОНЫ 07 ДУГААР САРЫН БАЙДЛААР)

I. Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлтүүд

	Хэмжих нэгж	2018	2019	2020	2021	2021 2020
1. Бэлэн хүн ам, мян.хүн *	мянган хүн	68.5	70.0	70.6	71.9	101.8
- Төрсөн хүүхдийн тоо**	тоо	792	750	831	874	105.2
- Нас барсан хүний тоо - бодит тоогоор**	тоо	234	222	194	197	101.5
- Хүн амын цэвэр өсөлт - бодит тоогоор	тоо	558	528	637	677	106.3
- Нялхасын эндэгдэл - бодит тоогоор	тоо	8	4	10	10	100.0
- 1000 хүүхдэд ноогдох	тоо	10.1	5.3	12.0	11.4	95.1
2. Ажилгүй иргэдийн тоо - бүгд	тоо	663	621	411	577	140.4
- Үүнээс эмэгтэй	тоо	308	308	197	262	133.0
- Хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох ажилгүй иргэдийн тоо	тоо	153	143	88	133	150.6
3. Шинээр бий болсон ажлын байр-бүгд	тоо	176	51	181	224	123.8
Үүнээс: Байнгын ажлын байр	тоо	76	19	99	75	75.8
Улирлын чанартай ажлын байр	тоо	100	32	3	5	166.7
Түр ажлын байр	тоо			79	144	182.3
4.Халдварт өвчний гаралт - бодит тоогоор	тоо	342	583	417	571	136.9
- 10000 хүнд ногдох	тоо	49	84	59	80	136.6
5. Гэмт хэргийн гаралт - бодит тоогоор	тоо	329	356	249	246	98.8
- 10000 хүнд ногдох ***	тоо	68	80	56	57	101.2
6.Бойжиж буй төл	толгой	591946	679524	732820	694896	94.8
- Унага	толгой	19003	18663	23633	24283	102.8
- Тугал	толгой	15858	14566	20497	20313	99.1
- Ботго	толгой	6512	6953	7927	7688	97.0
- Хурга	толгой	292632	339672	364724	346824	95.1
- Ишиг	толгой	257941	299670	316039	295788	93.6
7. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	сая төгрөг	112480.8	112191.1	90306.8	149143.0	165.2
- Борлуулсан бүтээгдэхүүн	сая төгрөг	152806.2	185187.7	145812.6	335107.7	2.3 ²

* - 2018,2019,2020 оны жилийн эцэст

**-Төрөлт, нас баралтыг ЭМГ-ын мэдээнээс авав.

*** - 18 - аас дээш насны 10000 хүнд ногдохоор тооцов.



НЭГ.ЭРҮҮЛ МЭНД

1.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ

	Хэмжих нэгж	2020 I-VII	2021 I-VII	Өсөлт	
		тоо		хувь	
1. Амбулаторын үзлэг	мян.хүн	227.6	265.0	37.4	116.4
2. Ор хоног	мян.хүн	73.0	10.4	-62.6	14.2
3. Урьдчилсан сэргийлэх тарилга	мян.хүн	6.7	6.9	0.2	103.0
4. Эмчлүүлсэн хүний тоо	мян.хүн	10.4	9.7	-0.7	93.3
5. Түргэн тусламжийн дуудлага	мян.хүн	11.6	10.7	-0.9	92.2
Үүнээс: алсын дуудлага	мян.хүн	2.1	1.8	-0.3	85.7
6. Осол гэмтлийн өвчлөл	хүн	1719	1435	-284	83.5
Үүнээс: нас баралт	хүн	33	33	0	100.0
7. Шинээр хяналтанд авсан жирэмсэн эх	хүн	1031	970	-61	94.1
Үүнээс: эхний 3 сартайн хяналт	хүн	934	903	-31	96.7
8. Амаржсан эх	хүн	823	865	42	105.1
Үүнээс: нас баралт	хүн	0	0	0	0.0
9. 1-5 хүртэл насны эндсэн хүүхэд	хүн	0	3	3	0.0
10. 1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	хүн	10	10	0	100.0

Эх үүсвэр: Аймгийн эрүүл мэндийн газар

1.2 ТӨРӨЛТ, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, сумаар жил бүрийн 07 сард

	Амаржсан эх	Эхийн эндэгдэл	Амьд төрсөн хүүхэд	1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	1-5 хүртэл насны эндсэн хүүхэд
	тоо				
Дүн	865	0	874	10	3
Айраг	1		1		
Алтанширээ					
Даланжаргалан					
Дэлгэрэх	2		2		
Иххэт	2		2		
Мандах					
Өргөн					
Сайхандулаан	1		1		
Улаанбадрах					
Хатанбулаг	3		3	1	
Хөвсгөл	1		1		
Эрдэнэ					
Сайншанд	651		657	7	1
Замын-Үүд	204		207	2	2

Эх үүсвэр: Аймгийн эрүүл мэндийн газар



1.3 БҮРТГЭГДСЭН ХАЛДВАРТ ӨВЧИН, төрлөөр, жил бүрийн 07 сард

	2020 I-VII	2021 I-VII	Өсөлт	
	тоо			хувь
Халдварт өвчний гаралт-Бүгд	417	571	154	136.9
Вирус гепатит	3	2	-1	66.7
Сүрьеэ	42	27	-15	64.3
Тэмбүү	71	38	-33	53.5
Заг хүйтэн	122	86	-36	70.5
Трихоминиаз	56	30	-26	53.6
Цусан суулга	36	11	-25	30.6
Коронавирус	0	332	332	0.0
Бусад	87	45	-42	51.7

Тайлбар- 2-дахин их

Эх үүсвэр: Аймгийн эрүүл мэндийн газар



ХОЁР. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

2.1 АЖИЛ ХАЙГЧ ИРГЭНИЙ ТОО, боловсролын түвшингээр, жил бүрийн 07 сард

Боловсролын түвшингээр	2018 VII	2019 VII	2020 VII	2021 VII	2021 VII 2018 VII	2021 VII 2020 VII
	хүний тоо				хувь	
ДҮН	663	621	411	577	87.0	140.4
Үүнээс: Эмэгтэй	308	308	197	262	85.1	133.0
Магистр, доктор	0	3	1	4	0.0	0.0
Дээд боловсролтой	99	69	95	120	121.2	126.3
Тусгай дунд	28	18	36	63	225.0	175.0
Техник мэргэжлийн	35	21	23	23	65.7	100.0
Бүрэн дунд	429	455	215	323	75.3	150.2
Бүрэн бус дунд	49	36	30	30	61.2	100.0
Бага	6	1	4	5	83.3	125.0
Боловсролгүй	17	18	7	9	52.9	128.6

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

2.2 АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар, жил бүрийн 07 сард

	Бүртгэлтэй иргэдийн тоо		Ажилд орсон иргэдийн тоо		Шинээр нэмэгдсэн иргэдийн тоо	
	2020 VII	2021 VII	2020 VII	2021 VII	2020 VII	2021 VII
ДҮН	411	577	776	368	1596	1088
Айраг	17	13	5	2	35	14
Алтанширээ	5	18	4	8	16	26
Даланжаргалан	6	15	0	0	11	18
Дэлгэрэх	5	1	0	0	10	2
Иххэт	3	0	3	0	10	0
Мандах	23	5	0	3	25	9
Өргөн	14	20	1	37	17	57
Сайхандулаан	9	6	3	1	25	8
Улаанбадрах	6	3	38	10	54	7
Хатанбулаг	21	13	55	31	89	44
Хөвсгөл	8	2	0	0	11	9
Эрдэнэ	34	18	7	32	46	68
Сайншанд	163	295	279	115	705	494
Замын - Үүд	97	168	381	129	542	332

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



2.3 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, эдийн засгийн салбарын ангилал, жил бүрийн 07 сард

Салбарын ангилал	2020 I-VII	2021 I-VII
	Тоо	
Бүгд	1052	479
ХАА, ан агнуур, ойн аж ахуй,загас барилт	8	0
Уул уурхай олборлох аж үйлдвэр	4	64
Боловсруулах үйлдвэрлэл	1	4
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	17	2
Усны хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент	41	4
Барилга	136	118
Бөөний ба жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар	26	18
Тээвэр агуулахын үйл ажиллагаа	9	9
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	7	1
Мэдээлэл, холбоо	20	0
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1	8
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0	0
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	1	0
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	355	111
Төрийн удирдлага, батлан хамгаалах, үйл ажиллагаа, албан журмын	46	12
Боловсрол	23	9
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ	30	28
Урлаг, үзвэр,тоглоом наадам	17	8
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	310	83
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа,өрхийн өөрийн	0	0
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	0	0

2.4 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, ажил, мэргэжлийн ангилал, жил бүрийн 07 сард

Үзүүлэлт	2020 I-VII	2021 I-VII
	Тоо	
Бүгд	1052	479
Менежер	14	11
Мэргэжилтэн	441	174
Техникч болон туслах дэд/ мэргэжилтэн	54	36
Контор, үйлчилгээний ажилтан	197	12
Худалдаа, үйлчилгээний ажилтан	59	23
ХАА, ой загас агнуурын ажилтан	1	0
Үйлдвэрлэл, барилга,гар урлал,холбогдох ажил үйлчилгээний	56	115
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	33	10
Энгийн ажил мэргэжил	130	95
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	67	3

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



2.5 АЖИЛД ЗУУЧИЛСАН ИРГЭД, ажил, мэргэжлийн ангиллаар жил бүрийн 07 сард

Үзүүлэлт	2020 I-VII		2021 I-VII	
	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй
	Тоо		Тоо	
Бүгд	776	469	368	189
Менежер	5	3	9	7
Мэргэжилтэн	370	267	166	109
Техникч болон туслах дэд/мэргэжилтэн	40	25	25	18
Контор, үйлчилгээний ажилтан	184	116	9	8
Худалдаа, үйлчилгээний ажилтан	36	20	15	12
ХАА, ой загас агнуурын ажилтан	1	0	0	0
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил	36	12	88	22
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч,	22	0	7	0
Энгийн ажил мэргэжил	79	25	47	12
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	3	1	2	1

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

2.6 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД ОРСОН ИРГЭН, эдийн засгийн салбарын ангиллаар 2021 оны 07 сард

Салбарын ангилал	Бүгд	Эмэгтэй	Бүгдээс: Ажлын байрны шинж, чанараар		
			Байнга	Улирал	Түр
	Тоо				
Бүгд	224	124	75	5	144
ХАА, ан агнуур, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	0				
Уул уурхай олборлолт	1	1		1	
Боловсруулах үйлдвэрлэл	3		3		
Цахилгаан, хий уур агааржуулалтын хангамж	0				
Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент	0				
Барилга	15	3	3	3	9
Бөөний ба жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ	24	12	23	1	
Тээвэр агуулахын үйл ажиллагаа	12	1	12		
Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	2	2	2		
Мэдээлэл холбоо	0				
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	5	3	5		
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0				
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	16	4	8		8
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	96	64	8		88
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын даатгал	29	22	3		26
Боловсрол	4	3	4		
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	1	1			1
Урлаг үзвэр тоглоом наадам	1		1		
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	15	8	3		12
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн аж ахуй	0				
Олон улсын байгууллагын үйл ажиллагаа	0				

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



ГУРАВ. НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

3.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, ТӨРЛӨӨР, ЖИЛ БҮРИЙН 07 САРЫН ЭЦЭСТ

Үзүүлэлт	2020 I-VII	2021 I-VII	2021 I-VII 2020 I-VII
	сая төгрөг		хувь
Нийгмийн даатгалын сангийн орлого	24 041.6	30 533.9	127.0
Тэтгэврийн даатгалын сан	15 088.6	21 575.1	143.0
Тэтгэмжийн даатгалын сан	1 714.0	1 801.5	105.1
Эрүүл мэндийн даатгалын сан	4 006.2	4 997.5	124.7
ҮОМШӨ*-ний даатгалын сан	2 523.1	1 804.3	71.5
Ажилгүйдлийн даатгалын сан	709.7	355.5	50.1
Нийгмийн даатгалын сангийн зарлага	34 554.0	36 729.3	106.3
Тэтгэврийн даатгалын сан	25 447.5	27 267.5	107.2
Тэтгэмжийн даатгалын сан	2 083.5	2 069.9	99.3
Эрүүл мэндийн даатгалын сан	4 381.1	5 010.1	114.4
ҮОМШӨ*-ний даатгалын сан	1 680.0	1 596.3	95.0
Ажилгүйдлийн даатгалын сан	961.9	785.5	81.7

3.2 НИЙГМИЙН ДААТГАЛД ДААТГУУЛАГЧИД, ОЛГОСОН ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭ, ТӨРЛӨӨР, ЖИЛ БҮРИЙН 07 САРЫН ЭЦЭСТ

Үзүүлэлт	2020 I-VII	2021 I-VII	2021 I-VII 2020 I-VII
	хүн		хувь
1. Нийгмийн даатгалд даатгуулагчид	20878	20132	96.4
Албан журмаар даатгуулагчид	17229	17038	98.9
Аж ахуй нэгж, байгууллага	8947	8880	99.3
Төсөвт байгууллага	8282	8158	98.5
Сайн дураар даатгуулагчид	3649	3094	84.8
2. Тэтгэвэр авагчдын тоо	9151	9510	103.9
Өндөр насны тэтгэвэр	6661	7014	105.3
Хөгжлийн бэршээлтэй иргэдийн	1349	1382	102.4
Тэжээгчээ алдсаны	490	469	95.7
Цэргийн тэтгэвэр	477	501	105.0
ҮОМШӨ*-ний	174	144	82.8
	сая төгрөг		
3. Олгосон тэтгэвэр	27 120.1	27 774.0	102.4
Өндөр насны тэтгэвэр	19 078.9	20 472.9	107.3
Хөгжлийн бэршээлтэй иргэдийн	2 947.8	3 223.5	109.4
Тэжээгчээ алдсаны	1 164.6	1 148.6	98.6
Цэргийн тэтгэвэр	2 248.8	2 413.1	107.3
ҮОМШӨ*-ний	1 680.0	515.9	30.7

Тайлбар: *-Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

Эх сурвалж: Нийгмийн даатгалын хэлтэс



3.3 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, сумаар

Сумын нэр	2020 I-VII	2021 I-VII	2021 I-VII 2020 I-VII
	сая төгрөг		хувь
ДҮН	24041.6	30533.9	127.0
Айраг	365.1	441.3	120.9
Алтанширээ	159.5	196.4	123.1
Даланжаргалан	934.3	1059.6	113.4
Дэлгэрэх	179.3	217.5	121.3
Иххэт	284.4	458.2	161.1
Мандах	180.6	225.3	124.8
Өргөн	406.4	790.0	194.4
Сайхандулаан	179.0	203.4	113.6
Улаанбадрах	206.7	239.6	115.9
Хатанбулаг	439.5	541.6	123.2
Хөвсгөл	188.2	232.7	123.6
Эрдэнэ	383.3	407.7	106.4
Сайншанд	13870.3	17639.8	127.2
Зүүнбаян баг	704.1	793.8	112.7
Замын-Үүд	5560.9	7087.0	127.4

3.4 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА, сумаар

Сумын нэр	2020 I-VII	2021 I-VII	2021 I-VII 2020 I-VII
	сая төгрөг		хувь
ДҮН	34554.0	36729.3	106.3
Айраг	1627.2	1690.6	103.9
Алтанширээ	628.3	669.1	106.5
Даланжаргалан	1413.3	1430.9	101.2
Дэлгэрэх	753.5	791.9	105.1
Иххэт	1155.2	1223.6	105.9
Мандах	730.0	768.1	105.2
Өргөн	1059.3	1130.7	106.7
Сайхандулаан	526.5	569.5	108.2
Улаанбадрах	735.6	831.6	113.1
Хатанбулаг	1276.2	1341.4	105.1
Хөвсгөл	634.8	673.1	106.0
Эрдэнэ	1152.5	1258	109.2
Сайншанд	15287.7	15812.8	103.4
Зүүнбаян баг	1224.5	1241.9	101.4
Замын-Үүд	6349.4	7296.1	114.9



3.5 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮНИЙ ТОО, ОЛГОСОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 07 сард

Үзүүлэлт	Хамрагдсан хүний тоо		2021 I-VII	Олгосон тэтгэвэр тэтгэмж		2021 I-VII
	2020 I-VII	2021 I-VII	2020 I-VII	2020 I-VII	2021 I-VII	2020 I-VII
	Тоо		хувь	сая төгрөг		хувь
НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ	22333	10597	47.4	5153.3	2630.4	51.0
1. Халамжийн тэтгэвэр	1338	1304	97.5	2016.9	971.9	48.2
Ахмад настны тэтгэвэр	95	102	107.4	141.2	58.8	41.6
Хөдөлмөрийн чадвараа 50-69% алдсан ХБИ	381	357	93.7	544.9	204.4	37.5
Хөдөлмөрийн чадвараа 70%-с дээш алдсан ХБИ	469	467	99.6	707.3	268.9	38.0
16 насанд хүрсэн одой иргэний тэтгэвэр	1	1	100.0	1.6	0.6	36.0
Тэжээгч нас барсан 18 хүртэлх насны хүүхдийн тэтгэвэр	392	377	96.2	621.9	439.3	70.6
2 Халамжийн тэтгэмж	1120	1154	103.0	641.7	690.0	107.5
Ахмад настныг асарч байгаа иргэнд олгох тэтгэмж	558	551	98.7	280.3	294.2	105.0
Байнгын асаргаа шаардлагатай, эмнэлгийн хяналтанд байдаг хөгжлийн бэрхшээлтэй 18 хүртэлх насны хүүхдийг асарч байгаагийн улмаас хөдөлмөр эрхлэдэггүй хөдөлмөрийн насны иргэн	238	255	107.1	191.0	208.9	109.4
Байнгын асаргаа шаардлагатай, эмнэлгийн хяналтанд байдаг хөгжлийн бэрхшээлтэй 18-аас дээш насны хүнийг асарч байгаагийн улмаас хөдөлмөр эрхлэдэггүй хөдөлмөрийн насны иргэн	263	293	111.4	135.1	152.1	112.6
Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж харгазан дэмжиж байгаа иргэнд олгох тэтгэмж	52	45	86.5	30.4	28.9	95.0
Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг мөн хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж	5	4	80.0	2.7	2.4	89.2
Тэжээн тэтгэх хүүхэдгүй, төрөл садангийн хүнгүй, ганц бие ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй ганц бие иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэн	4	6	150.0	2.2	3.5	157.3



Хүснэгт 3.5-ийн үргэлжлэл

Үзүүлэлт	Хамрагдсан хүний тоо		2021 I-VII 2020 I-VII	Олгосон тэтгэвэр тэтгэмж		2021 I-VII 2020 I-VII
	2020 I-VII	2021 I-VII		2020 I-VII	2021 I-VII	
	тоо		хувь	сая төгрөг		хувь
3. Амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн дүн	972	1045	107.5	442.4	584.4	132.1
